

**“ОРХОН СИСТЕМС” ХХК-ИЙН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ НӨХЦӨЛ /RAO/**

Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч (ОСДҮЭ) “Орхон системс” ХХК-ийн хэрэглэгчдэд түгээх сүлжээнд холбогдоход дараах техникийн нөхцөлийг хангасан байх шаардлагыг тавина.

Энэхүү нөхцөлийг Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам” (цаашид “Холболтын журам” гэх)-ын 2.5 дах хэсэгт заасныг баримтлан боловсруулсан болно.

“Орхон системс” ХХК нь Телевиз, радиогийн олон суваг дамжуулах №..... тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд өөрийн Кабелийн телевиз, Интернет үйлчилгээ хосолсон “BEYOND MEDIA” үйлчилгээгээ FTTH (Fiber to the home) технологиор Өвөрхангай аймгийн Хархорин хотын нутаг дэвсгэрт хүргэдэг.

1. Сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага

Телевизийн студиас өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт	HD/SD форматаар SMPTE 292M (HD/SD)
Дууны оролт	Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дүрсийн харьцаа	16:9
SD нягтрал	SD-SDi 625@50i
HD нягтрал	HD-SDi, 1080@50i шахалтын стандарт нь MPEG/AVC (H.264)
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад болон EBU R128 зөвлөмжийг мөрдөнө.
Дууны кодлол	Стерео болон MPEG layer 2

2. Зааглах цэгийн байршил, ашиглалт үйлчилгээ

2.1 Сүлжээнд холбогдох зааглах цэгийн боломжит байршлуудыг дараах хүснэгтэд харуулав.

Зааглах цэг байрлах хаяг (Боломжит зааглах цэгүүдийн байршил)	Зааглах цэг дэх холболтын тоног төхөөрөмжийн мэдээлэл (нэр, брэнд, үндсэн үзүүлэлт г.м)	Тайлбар
Байршил: /Орхон системс ХХК-ийн байр/	“Орхон системс” ХХК-ийн байр, Optic receiver, Optic transmitter	Зааглах цэгт өөрийн сигналыг хүргэхтэй холбоотой сүлжээний түрээс, татах, ашиглалт үйлчилгээг Телевизийн үйлчилгээ эрхлэгч хариуцна. /3 дахьч этгээдээр гүйцэтгүүлж болох ба энэ тухайгаа ОСДҮЭ-д заавал мэдэгдэнэ/

2.2 Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн студиас зааглах цэг хүртэлх сүлжээг (сүлжээ түрээслэх, татах, ашиглалт үйлчилгээ зэрэг) хариуцна.


2.3. Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь зааглах цэгийг дээр зааснаас өөр цэгт тогтоох саналтай бол хүсэлтийг албан бичигтээ тодорхой дурдаж, техникийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг ирүүлнэ. Хэрвээ тус

зааглах цэг нь Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын Хавсралт 4-д зааснаас өөр газарт байрлах бол албан бичгийн хувийг Зохицуулах хороонд илгээнэ.

2.4 Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

ОСДҮ-ний сүлжээнд холбогдоход нэмэлтээр тоног төхөөрөмж шаардлагагүй.

2.5 Холболтын схем, зураглал



3. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл

Гэрээ хийх процесс, бусад асуудлаар хэнтэй харилцах тухай “Хавсралт-3”-д дурдсаны дагуу харилцан шуурхай мэдээлэл солилцож, шуурхай шийдвэрлэнэ.

4. Сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл

Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын 2.9-д заасны дагуу Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээ байгуулах, төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй, мөн журмын 8-р хэсгийг баримтална.

<p>Зааглах цэг байрлах хаяг (Хэрвээ холболтын төлбөр нь зааглах цэгийн байршлаас хамаарах бол тус бүрд нь бичнэ)</p>	<p>Дамжуулалтын төлбөр (тухайн ТВ-ийг өөрийн сүлжээнд холбоход гарах өртөгт суурилсан зардал байх ба орон нутаг болон Улаанбаатар хотын хувьд тус тусад нь гаргана.)</p>	<p>Үндэслэл, тайлбар</p>
<p>Байршил: Байршил нь “Орхон систем” ХХК-ийн Optic receiver, Optic transmitter</p>	<p>Гэрээний 6.1 заасны дагуу Нийлүүлэгч нь энэхүү гэрээний хүрээнд суваг дамжуулалтын төлбөр төлөхгүй</p>	<p>Зааглах цэгээр дамжуулан хүлээн авч байгаа тул шаардлагагүй</p>

5. Гэрээний загвар



БАТЛАВ.
“.....” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

ХОЛБОЛТ, ДАМЖУУЛАЛТЫН ГЭРЭЭ

20.. оны ... дугаар сарын ...-ны өдөр № Улаанбаатар хот

Нэг: Гэрээ байгуулах үндэслэл, зорилго

1.1 Нэг талаас Улсын бүртгэлийн, регистрийн дугаартай “.....” ХХК /цаашид “Нийлүүлэгч” гэх/-ийг төлөөлж захирал нөгөө талаас Улсын бүртгэлийн, регистрийн дугаартай “.....” ХХК /цаашид “Дамжуулагч” гэх/-ийг төлөөлж /хамтад нь “Талууд”, зарим тохиолдолд дангаар нь “Тал” гэх / нар нь Дэлхийн Худалдааны Байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчмууд (Regulatory Principles Reference Paper /RPRP/), Харилцаа холбооны тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай болон бусад холбогдох хуулиуд, ХХЗХ-ноос батлагдан гарсан харилцан холболт, холболтын талаарх холбогдох журмууд болон тус тусын байгууллагын дүрэмд үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.2 Нийлүүлэгч нь Дамжуулагчийн сүлжээнд холбогдох болон Дамжуулагч нь Нийлүүлэгчийн бэлтгэсэн “.....” телевизийн хөтөлбөрийг бүрэн хэмжээгээр, HD/SD форматаар хүлээн авч, “BEYOND MEDIA” үйлчилгээгээр Улаанбаатар хотын айл өрх, албан байгууллагад чанарын өндөр түвшинд хүргэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

Хоёр. “Нийлүүлэгч”-ийн эрх, үүрэг:

- 2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Дамжуулагч талаас шаардах эрхтэй.
- 2.2 Дамжуулагч талын сүлжээгээр дамжин хэрэглэгчдэд очиж байгаа өөрийн бүтээгдэхүүний чанар, стандартад хяналт тавих эрхтэй.
- 2.3 Нийлүүлэгч тал нь Дамжуулагч талын сүлжээний холболтод хавсралт-1 дэх шаардлага болон MNS 5592-2:2016 стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг гэрээний 4.4-т заагдсан, зааглах цэгээр дамжуулан шилэн кабелиар Дамжуулагч талд тасралтгүй нийлүүлэх үүрэгтэй.
- 2.4 Өөрийн нэвтрүүлгээ MNS 5592-2:2016 стандартын шаардлага хангахуйц түвшинд дамжуулж эфирин сахилгыг сахиж, мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийн эх сурвалжийн үнэн бодит байдалд хяналт тавьж, эрх зүйн асуудлаа дангаараа бүрэн хариуцах үүрэгтэй.
- 2.5 Нийлүүлэгч нь өөрийн нэвтрүүлгийн хөтөлбөрийг үг үсгийн алдаагүй, хавсралт-4 дахь форматаар, Лхагва гараг бүр Дамжуулагчийн и-мэйл хаяг руу урьдчилан илгээж, хөтөлбөрийн цагийг баримтлах үүрэгтэй.
- 2.6 Нийлүүлэгч нь холболтын төв болон зааглах цэгт өөрийн өмчлөлд хамаарах тоног төхөөрөмжтэй бол түүний засвар үйлчилгээг өөрөө хариуцах бөгөөд найдвартай, аваар осолгүй, ашиглалтын болон технологийн горимыг Дамжуулагч талаас хамааралгүй зохион байгуулж ажиллах үүргийг дангаар хүлээнэ.
- 2.7 Нийлүүлэгч нь “Өргөн нэвтрүүлгийн тухай” хуулийн 4.1.21, 26.5-д заасан хариуцлагыг биелүүлэхтэй холбоотой Дамжуулагч талын ажилд саад учруулахыг хориглоно.

Гурав. “Дамжуулагч”-ийн эрх үүрэг:

- 3.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Нийлүүлэгчээс шаардах эрхтэй.
- 3.2 Нийлүүлэгчийн нэвтрүүлгийг, зааглах цэгээр дамжуулан, техникийн шаардлага хангасан шилэн кабелиар, Дамжуулагчийн хаягт байрлах HEADEND дээр хүлээн авч, “BEYOND MEDIA” үйлчилгээний хэрэглэгчдэд MNS 5592-2:2016 стандартын шаардлагын дагуу нийлүүлэгчийн ирүүлсэн сингалын түвшинг бууруулахгүйгээр дамжуулах үүрэгтэй.
- 3.3 Дамжуулагч нь зааглах цэг дэх өөрийн өмчлөлд хамаарах тоног төхөөрөмж, түүний ашиглалт үйлчилгээг өөрөө хариуцах бөгөөд найдвартай, аваар осолгүй, ашиглалтын болон технологийн горимыг Нийлүүлэгч талаас хамааралгүй зохион байгуулж ажиллах үүргийг дангаар хүлээнэ.

- 3.4 Дамжуулагч нь Нийлүүлэгчийн ирүүлсэн хөтөлбөрт өөрчлөлт оруулах эрхгүй ба зөрүүлснээс үүдсэн хариуцлагыг дангаар хүлээнэ.
- 3.5 Дамжуулах, хүлээн авах төхөөрөмжид гэмтэл гарсан, нийлүүлэгч тал байршлаа өөрчилсөн, зааглах цэгийн байршил өөрчлөгдсөн зэрэг шалтгааны улмаас холболтыг салгах, хязгаарлалт хийх тохиолдолд Зохицуулах хороонд болон нөгөө талдаа 72 цагийн өмнө үндэслэлийн хамт, дамжуулагч талын сүлжээний хэрэглэгчдэд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.
- 3.6 Дамжуулагч нь Нийлүүлэгч талын бэлтгэн цаашир байгаа нэвтрүүлэг контент нь Монгол улсын хууль дүрэм, хориглосон үйл ажиллагааг зөрчсөн эсэх талаар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй ба хөтөлбөр дундуур аливаа хэлбэрийн зар, сурталчилгаа дамжуулахыг хориглоно.
- 3.7 Нийлүүлэгчийн дамжуулж буй сувгийг “BEYOND MEDIA” үйлчилгээний сувгийн багцад оруулж, хэрэглэгчдэд мэдэгдэх үүрэгтэй.

Дөрөв. Хариуцлага:

- 4.1 Талууд гэмтэл саатал, засвар үйлчилгээ, хөтөлбөрийн өөрчлөлт, болзошгүй эрсдэлийг бууруулах болон бусад хэлбэрээр яаралтай холбоо тогтоох шаардлагатай бол “Хавсралт-3”-д дурдсан нөхцөлөөр харилцан шуурхай мэдээлэл солилцож, шуурхай шийдвэрлэнэ.
- 4.2 Талууд сар бүр холболтын тоног төхөөрөмжүүддээ урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээ, хэмжилт хийх бөгөөд нөгөө талынхаа хүсэлтээр болон тусдаа, мөн хамтран хийж болно. Нөгөө талын сүлжээнд нөлөөлөхүйц төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажил үйлчилгээ гүйцэтгэх бол нөгөө талдаа ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэж дамжуулалтыг таслахгүйгээр хийхийг хамтран шийдвэрлэнэ.
- 4.3 Сүлжээний холболттой хамаатай гэмтэл саатал, бусад засвар үйлчилгээг талууд 24 цагт багтаан засварлах ба 24 цагаас дээш хугацаа шаардлагатай бол агаарын болон бусад сүлжээгээр холбогдож, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.
- 4.4 Зааглах цэг нь”-д байрлах “.....” ХХК-ийн өмчлөлийн Optic receiver, Optic transmitter бүхий “Холболтын төв” дэхь шилэн кабелийн хүлээн авагч байна. Зааглах цэгийг зургаар “Хавсралт-2”-т үзүүлэв.
- 4.5 Талууд гэрээний 4.4-т зааснаас өөр цэгт зааглах цэг тогтоолгох хүсэлт гаргавал ХХЗХ-нд хандаж шийдвэрлүүлэх ба ХХЗХ шийдвэр гаргах хүртэл өмнө хэрэглэж байсан шийдэл, зааглах цэгээр үйлчилгээг тасралтгүй дамжуулах нөхцлийг бүрдүүлж ажиллана.
- 4.6 Зааглах цэг хүртэлх холболтын шилэн кабелийн түрээс, ашиглалт үйлчилгээг Нийлүүлэгч, Зааглах цэгээс HEADEND хүртэлх холболтын шилэн кабелийн түрээс, ашиглалт үйлчилгээг Дамжуулагч тал хариуцна.
- 4.7 Талууд зааглах цэг хүртэлх сүлжээг гуравдагч этгээдээс түрээслэх бол нөгөө талдаа заавал мэдэгдэж, харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 4.8 Гэрээнд оролцогч талуудын аль нэг нь үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа учруулсан бодит хохирлыг төлөх үүрэгтэй. (Шууд бус хохирол буюу олох байсан ашгийг нөхөн олгохгүй)
- 4.9 Талууд Монгол улсын хуульд заагдсан байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүдэлтэй техникийн саатал болон технологийн онцлогт сөргөөр нөлөөлөх цаг агаарын хүчин зүйлийн улмаас сигналын чанарт өөрчлөлт орох, тасрах нөхцөлд талууд харилцан үүрэг хүлээхгүй.
- 4.10 Дамжуулагч нь сувгийн дугаарлалтыг тогтоохдоо “Өргөн нэвтрүүлгийн тухай” хуулийн 26.7 болон гэрээ байгуулсан дарааллыг баримтлах тул телевиз нь “Beyond Media” үйлчилгээний үндсэн багцын-р суваг дээр байрлана. Нийлүүлэгчийн буруутай үйлдлээс шалтгаалж гэрээг түдгэлзүүлсэн, цуцалснаас үүдэн бусад сувгийн дугаарлалтад өөрчлөлт орохгүй ба тухайн сувгийн дугаарлалтыг дамжуулагчийн зүгээс бусад нийлүүлэгчид санал болгож болно.
- 4.11 Дамжуулагч нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой реклам, зар сурталчилгаа, нэвтрүүлгийг Нийлүүлэгч талын телевизээр харилцан тохиролцсоны үндсэн дээр дамжуулж болно.
- 4.12 Талууд сүлжээнд холбогдсоноос хойш гэнэтийн болон ослын нөхцөл байдал үүсэхээс бусад тохиолдолд холболтыг салгах, хязгаарлалт хийхийг хатуу хориглох ба гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлд гэрээний 7 дугаар зүйлийг баримтлана. Мөн ХХЗХ-ны зүгээс Нийлүүлэгчийн хөтөлбөрийг дамжуулахыг хориглосон, тусгай зөвшөөрлийг цуцласнаас бусад нөхцөлд сүлжээнд хязгаарлалт, салгалт хийхийг хориглоно.

Тав. Гэрээ цуцлах үндэслэл

- 5.1 Гэрээнд оролцогч талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзсан, Гэрээний нөхцөл дуусгавар болсон тохиолдолд гэрээг цуцалж болно.
- 5.2 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах тухай мэдэгдлээ талууд 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгэн хэлбэрээр мэдэгдэх ба нөгөө тал нь 10 хоногийн дотор ямар нэгэн хариу өгөөгүй тохиолдолд гэрээ цуцлагдсанд тооцож болно.
- 5.3 Гэрээнд оролцогч талуудын аль нэгэнд дараах нөхцөл байдал үүсвэл гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:
 - 5.3.1 Цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон болон дампуурснаа албан ёсоор зарласан;
 - 5.3.2 Үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан, сунгахаас татгалзсан;
 - 5.3.3 Эрх бүхий байгууллагаас үйл ажиллагааг нь зогсоох шийдвэр гарсан.

Зургаа: Төлбөр тооцоо

- 6.1 Нийлүүлэгч нь энэхүү гэрээний хүрээнд суваг дамжуулалтын төлбөр төлөхгүй.
- 6.2 Талууд сүлжээнд холбогдсон шилэн кабелийн түрээс, түүний ашиглалт үйлчилгээний төлбөрийг гэрээний 4.6 болон 4.7-г баримтлан тус тусдаа хариуцна.

Долоо: Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдгийг Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас гэрчилсэн тохиолдолд давагдашгүй хүчин зүйл гэж үзнэ.
- 7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 7.4 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, сүлжээний хэт ачаалал, гуравдагч этгээдийн буруугаас сүлжээний үйлчилгээ тасалдах, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.
- 7.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

Найм: Бусад

- 8.1 Гэрээнд талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж 20... оны ... сарын ...-ний өдрөөс 20... оны ... сарын ...-ний өдрийг дуустал ... жилийн турш мөрдөгдөнө.
- 8.2 Гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд ямар нэг саналгүй бол ижил нөхцөлөөр, ижил хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 8.3 Гэрээг 3 хувь үйлдэн баталгаажуулж талууд тус бүр нэг хувийг хадгалах ба 1 хувийг “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-д заасны дагуу ажлын 10 хоногийн дотор талууд хавсралтуудын хамт гэрээ, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг тухай бүр ХХЗХ-нд хүргүүлж бүртгүүлнэ. Гэрээний хувь тус бүр хуулийн өмнө адил, хүчин төгөлдөр байна.
- 8.4 Энэхүү гэрээнд тусгагдсан аливаа мэдээлэл нь үнэн зөв байдлыг хангасан байх ба тус мэдээллийг бусдад задруулсантай холбоотойгоор нөгөө талын ажил үйлчилгээнд сөргөөр нөлөөлсөн бол мэдээллийг задруулсан этгээдэд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 8.5 Талуудын эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар болон Гэрээний хавсралт, талуудын баталгаажуулсан нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 8.6 Гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудал гарвал талууд, эвлэрлийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хороо болон Монгол улсын хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

“Орхон системс” ХХК

Хаяг: Өвөрхангай аймаг, хархорин сум” байр

Утас: 77327099

Факс:

“Орхон системс” ХХК-ийг

төлөөлж:

Захирал *Б.Чулуунбат* Б.Чулуунбат

Утас: 99102246



“.....” ХХК

Хаяг:

Утас:

Факс:

“.....” ХХК-ийн

“.....” телевизийг

төлөөлж:

Албан тушаал

.....

Утас:



ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Холболт хийх техникийн нөхцөл:

- Холболт хийхэд шаардагдах техник төхөөрөмж, түүнд тавигдах шаардлага, стандарт үзүүлэлт зэрэг нь доор хүснэгтийн дагуу байх бөгөөд орсон өөрчлөлтийг тухай бүрд тусгаж байна.
- Телевизийн студиэс ирэх дохио нь Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандарт болон олон улсын стандарт, зөвлөмжүүдийг хангасан байна.
- Талуудын сүлжээ хооронд холболт хийх дамжуулах шугам нь(өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ)..... байна.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт	HD/SD форматаар SMPTE 292M (HD-SDI)
Дууны оролт	Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дүрсийн харьцаа	16:9
SD нягтрал	SD-SDI 625@50i
HD нягтрал	MPEG/AVC (H.264)
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	MNS 5592-2:2016 стандарт болон EBU R128 зөвлөмжийг мөрдөнө
Дууны кодлол	MPEGlayer 2

Холболтын техник, төхөөрөмжийн нэр, зориулалт	Телевиз талд	Дамжуулагч талд (ОСДҮЭ)
Хөрвүүлэх төхөөрөмж (Encoder) түүний төрөл, марк, сериал дугаар		
Дамжуулах (Tx) / Хүлээн авах (Rx) төхөөрөмж түүний төрөл марк, сериал дугаар	Tx	Rx
Холбох шугамын төрөл, үзүүлэлт	1 core fiber optic	1 core fiber optic
Холболтын интерфэйс	HD-SDI	HD-SDI
Бусад		

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ, ЗУРАГЛАЛ

Зааглах цэг:

- Зааглах цэг нь Дамжуулагч талын сүлжээний нэг хэсэг бөгөөд зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг Дамжуулагч тал хариуцна.
- Сүлжээний зааглах цэгийн байршил, холболтын зураглал нь доор заасны дагуу байна.

ЗААГЛАХ ЦЭГ, ТҮҮНИЙ ХОЛБОЛТ /дундын зааглах цэг/

ТАЛУУДЫН ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ

ГЭРЭЭ, КОНТЕНТЫН АСУУДЛААР	
Дамжуулагч тал “Орхон системс” ХХК Утас: 99102246 e-mail: chuluunbat0211@gmail.com	Нийлүүлэгч тал Маркетингийн алба Утас: e-mail:
ТЕХНИКИЙН АСУУДЛААР	
Захирал <i>Б.Чулуунбат</i> Б.Чулуунбат ОРХОН СИСТЕМС ХХК Утас: 99102246 e-mail: chuluunbat0211@gmail.com	Техникийн албаны дарга Утас: e-mail:
ХӨТӨЛБӨРИЙН ӨӨРЧЛӨЛТ, СУВГИЙН АСУУДЛААР	
Инженер <i>М.Түмэнцэцэг</i> М.Түмэнцэцэг Утас: 99311268	Маркетингийн алба Утас: e-mail:

ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨР ИРҮҮЛЭХ ФОРМАТ

“ТВ нэр” Телевизийн 20... оны ...-рсарын ...- ны гарагийн хөтөлбөр

Эхлэх цаг	Дуусах цаг	Нэвтрүүлгийн нэр
08:00	08:05	
08:05	08:30	
08:30	09:00	
09:00	10:00	
10:00	11:00	
11:00	11:20	
11:20	13:00	
13:00	14:00	
14:00	14:10	
14:10	15:00	
15:00	15:30	
15:30	17:00	
17:00	17:30	
17:30	17:50	
17:50	18:00	
18:00	19:00	
19:00	20:00	
20:00	20:10	
20:10	21:00	
21:00	21:30	
21:30	22:30	
22:30	23:00	
23:00	00:00	
00:00	00:30	
00:30	01:00	
01:00	08:00	